



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлж, ачааллыг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан Засгийн газрын гишүүд, албан тушаалтанд даалгасугай:

1.1.Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэхээр батлагдсан төсвийн хүрээнд ашиглалтад орох боломжгүй, ажлын тоо хэмжээ гэрээнд бүрэн тусгагдаагүйгээс орхигдсон, нэмэлт ажил гүйцэтгэх зайлшгүй шаардлага үүссэн боловсролын салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ажлын тоо хэмжээнд магадлал хийлгэж, Үндэсний аудитын газраар хянуулан, Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуульд тусгуулах бэлтгэл ажлыг хангахыг Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан нарт;

1.2.төсөвт өртөг нь батлагдаагүй, хүн амын нягтаршил ихтэй, боловсролын үйлчилгээ нэн шаардлагатай байршилд төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээг эрэмбэлж, нийслэлд хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээний эрхийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шилжүүлэх арга хэмжээ авахыг Боловсролын сайд Л.Энх-Амгаланд;

1.3.хүн амын нягтаршил ихтэй, боловсролын үйлчилгээ нэн шаардлагатай байршилд баригдах сургуулийн барилга, байгууламжид шаардлагатай газрыг чөлөөлөх асуудлыг нийслэлийн 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган шийдвэрлэж, шаардлагатай зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүжүүлэхийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Сангийн сайд З.Мэндсайхан, Боловсролын сайд Л.Энх-Амгалан нарт.

2.Салбарын хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон боловсролын сургалтын байгууллагын барилга, байгууламжийн жагсаалтыг шинэчлэн гаргаж, барилгын норм, дүрмийн шаардлагад нийцүүлэн засвар, шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх, шаардлагатай хөрөнгийг улсын төсөв болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх асуудлыг судлан санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян) нарт тус тус даалгасугай.

3.Боловсролын салбарын дэд бүтэц, хүртээмжийг нэмэгдүүлэн, боловсролын ачааллыг бууруулах чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд урт хугацаанд, үр ашигтай хамтран хэрэгжүүлэх төсөл боловсруулж, олон улсын болон хандивлагч байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Боловсролын сайд Л.Энх-Амгалан нарт тус тус даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

БОЛОВСРОЛЫН САЙД

Н.УЧРАЛ

Л.ЭНХ-АМГАЛАН